

**Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс**
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

# Анхдагчдыг дагах нь



Нэгэн удаа би Сүмийн эхэн үеийн анхдагчдын Солт Лэйк Валли руу явсан замуудаар алхан явсан юм. Би анхдагчдын явсан замаар явахдаа маш их даруусаж билээ. Гэвч тэдний алхсан замаар алхах нь тэдний амьдарсантай адил амьдрахаас илүү чухал биш юм.

Анхдагчид шинэ шашин, шинэ нутаг, аливааг үйлдэх шинэ арга зам руу итгэлтэйгээр хөл тавьсан. Тэд Бурханд итгэж найдсан. Бидэнд ч бас **итгэл** хэрэгтэй.

Тэд удирдагчдынхаа тэднээс хийхийг хүссэн зүйлийг хийсэн. Бид ч бас **дуулгавартай байх** хэрэгтэй.

Тэд Сионыг байгуулахаар авьяас чадвараа ашиглан, хамтдаа хөдөлмөрлөсөн. Бид ч бас **нэгдмэл байх** хэрэгтэй.

Тэд хэнийг ч орхиж яваагүй бөгөөд аян замд асуудал бэрхшээлтэй учирсан хүмүүсийг ч авч явсан. Бид ч бас **бүгдийг оролцуулдаг байх** хэрэгтэй.

Бид анхдагчдыг дагаснаар тэдэнд хүндэтгэл үзүүлж чадна. ●

*"Following the Pioneers,"* Ensign, *Nov. 1997, 72–74-өөс тохируулан авав.*